

## ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ЭРХИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР ИЛГЭЭХ ДАРААЛАЛ

1. [WWW.MCIS.GOV.MN](http://WWW.MCIS.GOV.MN) сайтад хандан Тусгай зөвшөөрөл цэсний Холбогдох баримт бичиг хэсгээс СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА-тай танилцах, “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох, түүнд хяналт тавих журам”, Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагатай танилцах.
2. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь төрийн мэдээллийн сангуудтай холбогдсон тул тус цахим программд бүртгүүлэх архитектор, инженер, техникийн ажилтнууд E-Mongolia платформд бүргүүлсэн байх.
3. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөл **СУНГАЛТ БОЛОН НЭМЭЛТЭЭР** хүссэн аж ахуйн нэгж, байгууллага инженер, техникийн ажилтны /мэргэжилтэн/ тус байгууллагад сүүлийн 3 сар тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байх.
4. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөл **ШИНЭЭР** хүссэн аж ахуйн нэгж, байгууллага инженер, техникийн ажилтны /мэргэжилтэн/ тус байгууллагад сүүлийн 1 сар тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байх.
5. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөл **СУНГАХ** болон **АЖЛЫН ТӨРӨЛ НЭМЭХ**-ээр хүссэн аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааны тайлан, мэдээг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ дүгнэх актын дагуу биелэлтийг гаргаж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хот байгуулалтын хэлтэст илгээсэн байх. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөл авснаас хойш гүйцэтгэсэн ажлын тайлан [www.mcis.gov.mn](http://www.mcis.gov.mn) сайтад гүйцэтгэсэн ажлын тайлан хэсэгт ажлын гэрээг хавсаргах, Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөл авснаас хойшхи хугацаанд Барилгын норм, норматив боловсруулах санд төсөвт өртгийн 0.18 хувиар шимтгэл төлсөн баримтуудын хуулбарыг хавсаргах.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС  
УТАС: 70003959**

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ

Эрхийн зөвшөөрөл хүсэх тухай

Манай аж ахуйн нэгж, байгууллага нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах дараах ажлын хүрээнд эрхийн зөвшөөрөл ..... /авах, сунгуулах, ажлын төрөл нэмэх/-аар хүсэлтээ илэрхийлж байна: Үүнд:

- ХБ-1.1 Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах;
- ХБ-1.2 Бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл” боловсруулах;
- ХБ-1.3 “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах; /Зөвхөн хүсэлт гаргаж байгаа ажлын төрлийг сонгож бичих/

Эрхийн зөвшөөрөл ..... /авах, сунгуулах, ажлын төрөл нэмэх/-аар бүрдүүлсэн баримт бичиг нь үнэн зөв бөгөөд шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрыг үзүүлэхэд бэлэн болно.

ДАРГА / ЗАХИРАЛ / ..... /Овог нэр/

Гарын үсэг

Тэмдэг

Огноо

**Тайлбар:** Байгууллагын албан ёсны хэвлэмэл хуудсыг ашиглах ба хэвлэмэл хуудас нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар батлагдсан “ТӨРИЙН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗААВАР”-ын 2.3 дахь шаардлагыг хангасан байна.